



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

1. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “... Засгийн газар, төрийн бусад байгууллага хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг 10 хоногийн дотор мэдээллийн нэгдсэн санд байршуулж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас 2026 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн ТГ-03/619 тоот албан бичгээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санд хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайлан, зөвлөмжийн байршуулах ажлыг зохион байгуулах чиглэлийг өгсөн. Үүний дагуу Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг боловсруулав.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасныг удирдлага болгов. Улмаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийн хэрэгжилтийг үнэлэх хүрээг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт 1. Үнэлэх хүрээ

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, заалт
1	Нэгдүгээр бүлэг, Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт
		2 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж
		3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ
		4 дүгээр зүйл. Нэр томьёоны тодорхойлолт
		5 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээнд баримтлах зарчим
2	Хоёрдугаар бүлэг Виртуал хөрөнгийн үйлчилгээ	6 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ
		7 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага
		8 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг
		9 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ
3	Гуравдугаар бүлэг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, хяналт,	10 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих
		11 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах
		12 дугаар зүйл. Баримт бичгийн хадгалалт, хамгаалалт

баримтын хадгалалт, хамгаалалт, нууцлал	13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал
	14 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилийг үнэлэхдээ аргачлалын 3.4-д заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг харгалзан сонгов.

Шалгуур үзүүлэлтүүдээс:

- Зорилгод хүрсэн түвшин
- Практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, хуулийн үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг шалгах, тэдгээрийг хэмжих боломжтой байдлыг харгалзан сонгов.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хүснэгт 2. Үнэлгээ харьцуулах хэлбэр

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, заалт	Харьцуулах хэлбэр
1	Нэгдүгээр бүлэг, Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Байх ёстой болон одоо байгаа Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
		2 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж	
		3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ	
		4 дүгээр зүйл.Нэр томъёоны тодорхойлолт	
		5 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээнд баримтлах зарчим	
2	Хоёрдугаар бүлэг Виртуал хөрөнгийн үйлчилгээ	6 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ	
		7 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага	
		8 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг	
		9 дүгээр зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ	
3	Гуравдугаар бүлэг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, хяналт,	10 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих	
		11 дүгээр зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах	
		12 дугаар зүйл.Баримт бичгийн хадгалалт, хамгаалалт	
		13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал	

баримтын хадгалалт, хамгаалалт, нууцлал	14 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс	
---	---	--

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд тус хуулийн хэрэгжилт одоогийн нөхцөл байдалд нийцэж буй эсэх, төрийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллага, бусад этгээдийн эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа болон уг хуулийн нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоосон.

1.5. Мэдээлэл цуглуулах арга

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр зэргээс хамаарч тоон болон чанарын мэдээллийг ашиглаж дараах мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно. Үүнд:

- Баримт бичгийн судалгаа: ВХҮҮ-ийн талаар хийгдсэн болон бусад судалгааны тайлан, холбогдох статистик, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.

2. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Ингэхдээ холбогдох байгууллагуудаас авсан статистик, тоон мэдээлэлд суурилав. Үүнд үндэсний хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт, өмнө хийгдсэн судалгааны тайлангуудад дүн шинжилгээ хийлээ.

2.1. Статистик, тоон мэдээ цуглуулах

Санхүүгийн зохицуулах хороонд 2026 оны нэгдүгээр улиралд 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүртгэлтэй байна. Тэдгээрийн арилжааны самбарт нийт 36 дотоодын виртуал хөрөнгө арилжаалагдаж байна.

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 2026 оны нэгдүгээр улиралд өссөн дүнгээр нийт 190.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд үүнийг задлан харвал дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн 30.6 тэрбум төгрөг, гадаадын виртуал хөрөнгийн арилжааны дүн 159.5 тэрбум төгрөг байна. Тус 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр давхардсан тоогоор нийт 724,671 харилцагч бүртгэлтэй байна. Үүний 66.8 хувь баталгаажуулалт хийсэн, 2.6 хувь идэвхтэй арилжаа хийдэг харилцагч байна.

Тэдгээрийн 2026 оны нэгдүгээр улирлын урьдчилсан санхүү байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт хөрөнгийн дүн 52.9 тэрбум төгрөг байна. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдээс харахад тайлант үеийн нийт ашиг (2.2) тэрбум төгрөг, нийт орлогын дүн 874.3 сая төгрөг, зарлага нь 3.1 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 3. Виртуал хөрөнгийн зах зээлийн тоон мэдээлэл /2026 оны нэгдүгээр улирал/

Үзүүлэлт	2025-01	2026-01
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо /улирлаар/	12	12
Харилцагчийн тоо	941,180	724,671
Идэвхтэй арилжаа хийдэг	11,748	18,770
Баталгаажуулалт хийсэн	464,939	484,021
Дотоодын виртуал хөрөнгийн тоо	37	36
Дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	167,020,076,311	188,859,727,555
Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр хийгдсэн дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн	16,040,378,531	30,600,506,441
Дотоодын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа	178,226,428.12	340,005,627
Гадаадын виртуал хөрөнгийн тоо	403.00	685
Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр хийгдсэн гадаадын виртуал хөрөнгийн арилжааны дүн	401,164,464,967	159,484,751,486
Гадаад виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа	4,457,382,944.07	1,772,052,794
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	24,931,289,195.00	24,931,289,195.00
Нийт хөрөнгийн хэмжээ	76,021,937,066.81	52,984,636,629
Орлогын хэмжээ	2,264,544,846	874,255,859
Зардлын хэмжээ	4,330,074,764	3,117,912,057
Ашиг	-2,065,529,917	(2,243,656,198.01)

3. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль ба олон улсын эрх зүйн эх сурвалж

Олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стандартыг тогтоогч байгууллага Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ-аас 2018 оны 10 дугаар сар болон 2019 оны 6 дугаар саруудад тус тус техникийн зөвлөмждөө өөрчлөлт оруулж “Шинэ технологи” буюу Техникийн зөвлөмж 15-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн ФАТФ-аас 2019 оны 6 дугаар сард “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх заавар”-ыг боловсруулж, улс орнуудыг ФАТФ-ын шаардлагыг биелүүлэн, 1 жилийн дотор виртуал хөрөнгийн салбарт зохих зохицуулалтыг бий болгох үүрэг өгсөн.

Энэ хүрээнд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын Зөвлөмж 15 (Шинэ технологи)-ын шаардлага, стандарт болон олон улсын сайн туршлагуудад үндэслэн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд нь “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн №06 дугаарт хэвлэгдсэн бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын Зөвлөмж 15-д нийцэж буй эсэх

Хуулийн зорилт

ФАТФ-ын Техникийн зөвлөмж 15 (Шинэ технологи)-ийн 15.4.а-д виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь үүсгэн байгуулагдсан улсдаа бүртгүүлэх, эсвэл зөвшөөрөл авахыг шаарддаг. Иймд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх болон хяналт зохицуулалтад байх үүрэг хүлээсэн бөгөөд ФАТФ-ын Техникийн зөвлөмж 15-д тавьсан шаардлага хуульд заасан гэж үзэхээр байна.

3.2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн зохион байгуулалтын хэрэгжилт

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д зааснаар тус 6 дугаар зүйлийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж, мөн тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т виртуал хөрөнгийг аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгө гэж тус тус тодорхойлсон. Тухайлбал, виртуал хөрөнгийг арилжаалах, шилжүүлэх, хадгалах, удирдах үйлчилгээ үзүүлж буй компанийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж томъёолсон.

Тус хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх үүрэг хүлээж, мөн тус хуулийн 10 дугаар зүйлд Хорооны бүрэн эрхийг тогтоосон. Тухайлбал, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөрдөн ажиллах холбогдох журмуудыг батлах, хяналт тавих чиг үүргийг зохион байгуулах, үйл ажиллагааг түр зогсоох, бүртгэлээс хасах зэрэг бүрэн эрх олгогдсон.

Үүний хүрээнд тус Хорооноос 2022 оны 4 дүгээр сард виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөрдөх холбогдох 8 журмыг баталсан. Түүнчлэн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 09 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, 10 хуулийн этгээдийг, харин 2023 онд

шинээр 2 хуулийн этгээдийг тус тус бүртгэсэн. Дээрх хугацаанд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт ирүүлээгүй, хүсэлт ирүүлсэн боловч холбогдох журмын шаардлагыг хангаагүй нэр бүхий 14 хуулийн этгээдэд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааг зогсоох, харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийг буцаан шилжүүлж, аливаа үүргийг барагдуулах хугацаатай үүрэг, даалгавар өгсөн. Үүний үр дүнд тус Хороонд бүртгэлгүй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан 14 хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, цахим платформыг хаалгах ажлыг зохион байгуулсан.

Мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д зааснаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээд нь тус Хороонд бүртгүүлсэн байхаар зохицуулсан. Нэр бүхий 6 компанийг ВХҮҮ-ийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдээр холбогдох журамд заасны дагуу бүртгэсэн.

3.3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны арга хэлбэр, түүний хэрэгжилт

Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэснээр хуульд заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих харилцаа хэрэгжиж эхэлсэн. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ зайны болон газар дээрх хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Зайны хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ виртуал хөрөнгийн хяналтын систем болох “Chainalysis” программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. “Chainalysis” систем нь 2 төрлийн модулийг санал болгодог. Нэгдүгээр модулиар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн ерөнхий мэдээлэл, харилцагчийн задаргаа, гүйлгээний түүхийг харах, виртуал хөрөнгийн урсгалыг мөшгөх зэрэг боломжтой бол хоёрдугаар модулиар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, эрсдэлийн дохиог тухай бүрд хүлээн авах боломжтой. Мөн тус Хорооны API системд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгчдийн тоо, ханшийн мэдээлэл зэргийг өдөр бүр API системээр авч, хянан ажиллаж байна. Зайны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд холбогдох үүрэг даалгавар, улсын байцаагчийн албан шаардлага, зөрчил шалган шийдвэрлэх зэрэг холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн.

Газар дээрх хяналт шалгалтын ажлын хүрээнд 2023–2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 22 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Мөн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулж, 1 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулсан. Хяналт шалгалтаар холбогдох хууль тогтоомж, батлагдсан журам, зааврын хэрэгжилт, хэрэглэгчийн хөрөнгийн найдвартай хадгалалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, виртуал хөрөнгийн арилжаа, шилжүүлэг, хадгалалтын үйл ажиллагаа, хэрэглэгчийг таньж мэдэх, гүйлгээний

хяналт, сэжигтэй гүйлгээ илрүүлэх үйл ажиллагаа, мэдээллийн системийн аюулгүй байдал, найдвартай, тасралтгүй ажиллагааны нөхцөл байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг даалгавар өгч ажилласан.

4. ДҮГНЭЛТ

Хүснэгт 4. Үнэлгээний хураангуй

№	Үнэлэх зүйл, заалт	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл				
1	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Тийм	Тийм	Тийм
	2 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж	Тийм	Үгүй	Үгүй
	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	Тийм	Тийм	Үгүй
	4 дүгээр зүйл. Нэр томъёоны тодорхойлолт	Тийм	Үгүй	Үгүй
	5 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээнд баримтлах зарчим	Тийм	Үгүй	Үгүй
Хоёрдугаар бүлэг. Виртуал хөрөнгийн үйлчилгээ				
2	6 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ	Тийм	Үгүй	
	7 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага	Тийм	Тийм	Үгүй
	8 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг	Тийм	Тийм	Тийм
	9 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ	Тийм	Тийм	Тийм
Гуравдугаар бүлэг. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, хяналт, баримтын хадгалалт, хамгаалалт, нууцлал				
	10 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих	Тийм	Тийм	Үгүй
	11 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ	Тийм	Тийм	Үгүй

3	үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах			
	12 дугаар зүйл.Баримт бичгийн хадгалалт, хамгаалалт	Тийм	Тийм	Үгүй
	13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал	Тийм	Тийм	Тийм
	14 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс	Тийм	Үгүй	Үгүй
Нийт		14/14	10/14	4/10
		100%	71%	28%

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль нь Монгол Улсад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг анх удаа хуульчлан зохицуулж, бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлсэн эрх зүйн суурь зохицуулалт болсон байна. Тус хууль батлагдсанаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг төрийн зохицуулалтын хүрээнд хамруулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагааг ил тод болгох үндсэн зорилгууд тодорхой хэмжээнд хэрэгжсэн байна.

Үнэлгээний үр дүнгээс харахад хууль хэрэгжсэнээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн бүртгэлийн тогтолцоо бүрдэж, хяналт шалгалт, тайлагнал, эрсдэлийн үнэлгээний механизм бий болсон нь салбарын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлжээ. Түүнчлэн ФАТФ-ын Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах эрх зүйн үндэс бүрдэж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан байна.

Нөгөө талаас хууль хэрэгжиж эхэлснээс хойш виртуал хөрөнгийн зах зээл, технологийн хөгжил эрчимтэй өөрчлөгдөж, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болсон нь одоогийн зохицуулалтын хүрээ зарим талаар хангалтгүй болсон нөхцөл байдлыг үүсгэжээ. Ялангуяа стэйблкойн, төвлөрсөн бус санхүүгийн үйлчилгээ (DeFi), үл орлогдох токен (NFT), бодит хөрөнгөд суурилсан токен, төвлөрсөн бус удирдлагын тогтолцоо (DAO) зэрэг шинэ харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт хуульд тусгагдаагүй байна.

Түүнчлэн Монгол Улсын иргэдийн виртуал хөрөнгийн арилжааны томоохон хэсэг нь Монгол Улсад бүртгэлгүй гадаад платформуудаар дамжин хийгдэж байгаа бөгөөд эдгээр платформд үндэсний хууль тогтоомжийн хяналт бүрэн хэрэгжихгүй байгаа нь хуулийн үр нөлөөг бууруулж байна. Үүнээс шалтгаалан хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөх, хууль бус үйл ажиллагааг илрүүлэхэд хүндрэл үүсэх, төрийн байгууллагаас тавих хяналт хязгаарлагдах зэрэг эрсдэлүүд хэвээр байна.